



## НИЙСЛЭЛИЙН НАРКОЛОГИЙН ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЭМЧИЙН ТУШААЛ

2014 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

### Наркологийн эмнэлгийн чанарын албаны дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2012 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "чанарын албаны дүрэм батлах тухай" 06/25 тоот, Наркологийн эмнэлгийн ерөнхий эмчийн 2012 оны 10 –р сарын 10-ны өдрийн 57 тоот тушаалуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ.

Тус эмнэлгийн чанарын албаны дүрмийг 1-р хавсралтаар, эмнэлгийн чанарын багийн бүрэлдэхүүнийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

1. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил аргагүйгээр ханган ажиллахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д. Гантөмөр/-д даалгасугай.
2. Эмнэлгийн тусламжийн чанар сайжруулах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг ерөнхий ня-бо /Ч. Түвшинбат/ –д үүрэг болгосугай
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албыг шинэчлэн байгуулах тухай 57, 2012 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн Чанарын багийг байгуулах, чанарын дүрмийг батлах тухай 44 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЭМЧ

Б. ОЮУНЧИМЭГ